

943



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2012 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 2239

Улаанбаатар хот

Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр
гадаадад суралцуулах тухай

Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 217 дугаар тогтоолоор баталсан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах журам”-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. Даваасүрэн овогтой Долзодмааг АНУ-ын Пурдуге их сургуулийн бакалаврын сургалтад инженерийн чиглэлээр 4 жил, Лхамсүрэн овогтой Лувсандондовыг АНУ-ын Иллинойсын их сургуулийн бакалаврын сургалтад мэдээллийн технологийн чиглэлээр 4 жил, Батсайхан овогтой Батхуягийг АНУ-ын Массачусеттийн их сургуулийн бакалаврын сургалтад инженер технологийн чиглэлээр 4 жил, Батцэнгэл овогтой Цацралыг АНУ-ын Мичиганы их бакалаврын сургалтад инженерийн чиглэлээр 4 жилийн хугацаагаар тус тус суралцуулсугай.

2. Суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэлийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.



Ё.ОТГОНБАЯР